



МАХ ИМПЭКС ХК-НИЙ 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН УЙЛ
АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮТҮЙН ТАЙЛАН

2021.07.29

Агуулга:

- Компаний танилцуулга
- Бизнесийн Үйл ажиллагаа
- Санхүүгийн Үйл ажиллагааны тайлан
- Компаний хэтийн төлөв





КОМПАНИЙ ЕРОНХИЙ ТАНИЛЦУУЛГА

МАХИМПЭКС ХК-ИЙН 2021 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛЭН

www.makhimpex.mn

Компанийн танилцуулга



1946 онд нийслэл хотыг Мах, Махан бүтээгдэхүүнээр хангах чиг УҮРЭГТЭЙ “Боловсон Мах комбинат” нэртэйгээр байгуулагдаж 75 дах жилдээ ажиллаж байгаа хүнсний ууган үйлдвэр юм.



МАХИМПЭКС ХК-ИЙН 2021 оны 1-р хагас жилийн тайлан

Компаний танилцуулга



Компани нь хотын төмөр замын сүлжээнд мал, түүхий эд, бараа материалын болон мах бэлэн бүтээгдэхүүн ачиж, буулгах зориулалтын хэд хэдэн салaa замуудаар холбогдсон, үйлдвэрлэлийг тасралтгүй жэвийн явуулах эрчим хүч, ус, дугаан хангамжийн найдвартай эх үүсвэр бүхий төвлөрсөн системд холбогдсон.

Хэрэглэгчдэд нийлүүлж буй бүтээгдэхүүнд стандарт аргачлалын дагуу өдөр тутам шинжилгээ хийж, дунг үндэслэн чанарын баталгаа олгохын зэрэгцээ үйлдвэрлэлийн орчны эрүүл ахуй, ариун цэврийн байдалд микробиологийн шинжилгээ хийж, байнгын хяналт тавьж ажилладаг тул манай компанийн бүтээгдэхүүн нь чанарын баталгаатай, эрүүл ахуйн хувьд найдвартай тооцогддог.

Компанийн үнэт зүйлс



Эрхэм зорилго

Бид дэвшилтэт техник технологи ашиглан Эрүүл мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаалаад, дотоодын зах зээлийн нийлүүлж, хэрэглэгчдээ дээдэлсэн, салбартай манлайлдагч байна

Алсын хараа

Чанар стандартгаар тэргүүлсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг компани болох

Үриа уг

Эрүүл махан бүтээгдэхүүн ЭХ ОРНЫ БАЯЛАГ



ҮЙЛДВЭРИЙН ХҮЧИН ЧАДАЛ /ӨДӨР/



Бог мал – 8000 толгой нийдлах



Бод мал – 800 толгой нийдлах



Гахай – 300 толгой нийдлах



340 тн тураг мал, дотор эрхтэн, дайвар
бүтээгдэхүүнийг боловсруулах Үйлдвэр



16000 тн тураг мал хадгалах
зориудтай

ХУНИЙ НӨӨДР



Нийт ажилчдын тоо – 125
орчим




Үйлдвэр – 105



Захиргаа – 20

Эрэгтэй – 67
Эмэгтэй – 58



ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛУУД



- Нийслэл хотынхоо хүн амьтгах, махан бүтээгдэхүүнээр хангаж байгаа
- Монгол мальн махыг дэлхий нийтэд таниулах онцгой үүрэг гүйцэтгэж Ази, Европ, Ойрхи Дорнодын орнуудад Max, махан бүтээгдэхүүн экспортлох арвин туршлага хуримтуулсан байна
- Иновацийн хөгжлийн хурээнд 2000 оноос үйлдвэрлэлийн үр ашгийг дээшилүүлэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор ХЕНГГУ-ын ‘Multivac’, “Textor” брендинь бүрэн ажиллагатай автомат машин суурилуулан, Европын техник, технологийг үйлдвэртээ бүрэн нэвтрүүлэн техник, технологийн иж бүрэн шинэчлэгтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байдаг.
- ISO9001:2008 олон улсын чанарын удирдлагын систем нэвтрүүлж, салбартаа анхдагч болсон
- Мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийг дээшилүүлэх орчин үеийн техник технологитой танилцуулхаар махны үйлдвэрүүдийн тоног төхөөрөмж технологийн дэлхийн чиг хандлагыг тодорхойлдог гурван жилд нэг удаа ХБНГУ-ын Франкфурт хотод зохиогдлог Олон улсын нэр хүндтэй IFFA үзэсгэлэнд сүүлийн 3 удаа тоотмои олонцож байна.

Онцлох Үйл явдал



Ковид-19 цар тахлын улмаас 2021 оны 4-р сарын 30-ны өдөр цахимаар хоёр дахь удаа “Хувьцаа Эзэмшигчийн” ээлжит хурлыг зөхион байгуулсан. Хураалд нийт 3800/721 ширхэг хувьцаа эзэмшсэн 9873 хувь нийлүүлэгчдээс 2649/178 ширхэг хувьцаа эзэмшсэн 52 хувь нийлүүлэгч нь компанийн нийт хувьцааны 69.7 хувь тул Хувьцаа эзэмшигчийн хурлыг хучин төгөлдөрт тооцон хураалдсан.

Үндэсний уутган хунсний Үйлдвэрүүд болох “Талх Чихэр” ХК “Мах Имлэкс” ХК, “Милл хаус” ХХК ийн хамт олон “Ногоон хишгигтэн” ТББ-тай хамтран Богдхан Уульян Ширээт болон Арцатын ам бүхий 10 га газар 8000 гаруй мод тарих ажлыг зуны дунд сарын шинийн 4-ний Дашнямтай бишэгт сайн өдөр эхлүүлж, бумба тавих арга хэмжээг зохион байгууллаа.





БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МАХИМПЭКС ХК-ИЙН 2021 оны 1-р хагас жилийн тайлан

www.makhimpex.mn



НӨӨЦИЙН МАХНЫ ХУДАЛЦАА – 2021 ОНЫ ХАВАР

Нийслэл хотын амьн 2021 оны хаврын утирлын хүсний хэрэгцээнд зориулан нөөцийн махны худалдаанд гаргаж ажилласан.



2021.01.02 - 2021.06.30



Сүхбаатар, Чингэлтэй, Сонгино хайрхан,
Баянгол дүүргийн дэлгүүрүүдэл нөөцийн
МАХ НИЙЛҮҮЛСЭН.



Хонь – 945 тн, Үхэр – 472 тн, Ямаа –
157 тн



Нөөцийн махны өргөтгөсөн худалдаа

Иргэдийн дунд махны амт, чанарт сэтгэгдл өндөр, эрэлт ихтэй байсан тул Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2021 оны дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан ажлын хэсэгтэй хамтран нөөцийн махны өргөтгөсөн худалдааг зохион байгуулж ажилласан. Дэлгүүрт нийлүүлсэн нөөцийн мах болон өргөтгөсөн худалдаагаар нийт 1574 тонн мах борлуулсан.



БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



Номин сүлжээ супермаркетэд ‘Max Импэкс’ нэрийн барааны 3 дэлгүүртэй бөгөөд Уүнийг хөгжүүлэн цаашид сүлжээ дэлгүүрт хэрэлтэгчийн хүсэл, сонирхолд нийцсэн сав баглаа боодол бүхий бүтээгдэхүүн үйлчилгээ болсон butchery shop-г нээж зах зээлд нойтон махны үйлчилгэг сайжруулан ажиллаж байна.

Дотоодын зах зээлд шинээр худалдаан гаргах бүтээгдэхүүнүүд:



ГЭР БҮЛИЙН БАГЦ
ХОНИНЫ СТЕЙК 1 кг



МАХИМПЭКС ХК-ИЙН 2021 оны 1-р хагас жилийн тайлан

www.makhimpex.mn

Ковид-19 цар тахлын үед авсан арга хэмжээ



- ✓ Аарц, аньс, чацаргана шүүсийт өдөр бур ажлын байранд 2-3 удаа уулгах
- ✓ Тогтмол давтамжтай хутгацаанд PCR, түргэвчилсэн шинжилгээнд хамруулж байгаа
- ✓ Нийт ажилчдаа вакцинжуулаалтанд хамруулсан
- ✓ Ариун цэвэр, хөдөлмөр хамгааллын зардлыг хэвийн нэмсэн
- ✓ Ажлын байрыг хадгааж Улдэх
- ✓ Шаардлагатай нөхцөлд гэрээсээ ажиллах
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар амжилттай зохион байгуулсан
- ✓ Махны үнийн хөөрөгдөл Үүсгэхгүйтээр тогтвортой үнийг барьж ажилласан





ҮЙЛДВЭРИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛУУД

- Хөргөлтийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хурээнд 5-н аммиакын насос худалдан авч суурилуулах шатанд явагдаж байгаа.
- Хөлдөөх конденсаторын (-40 градус) тоног төхөөрөмж захиалгаар авч угсрached бэлэн болгосон.
- Машин танхим болон 101-Хөлдөөх зоорийн барилгын засвар үйлчилгээ хийж дуусгасан
- Үйлдвэрийн туннэл-д мах сэрвээх зориулалттай тэргэнцэртэй өлгүүр 50 ш шинээр худалдан авч бэлтгэсэн
- Машины ачилтын хэсэгт ус зайлдуулах асуудлыг шийдвэрлэж талбайг цементэлсэн.



Санхүүгийн Үйл ажиллагааны тайлан

МАХИМПЭКС ХК-ИЙН 2021 оны 1-р хагас жилийн тайлан

www.makhimpex.mn



Санхүүгийн тайлан

Max Импэкс ХК нь 2021 онд 130 гаруй ажилтантайгаар 10 гаруй нэр төрлийн мах, Махан бүтээгдэхүүн, 20 гаруй нэр төрлийн дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулалт хийсэн.

2021 онд санхүүгийн хувьд манай компани нь бизнес төлөвлөгөөнд тусгасан зорилтын хурээнд:

1. Санхүүгийн эх уусвэрийг татан төвлөрүүлэх, санхүүжилтийг бий болгох замаар борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх
2. Нядалгаа болон үйл эжиллагааны хучин чадлыг нэмэгдүүлэхийн тулд тоног төхөөрөмж, техник технологийн шинэчлэл хийх
3. Махан бүтээгдэхүүний нэр төрөл, махны экспортыг тэлэх замаар ашигт ажиллагааг нэмэгдүүлэх
4. Бүтээгдэхүүний өртгийг зохистой түвшинд барьж ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан.

Санхүүгийн тайлан



Компанийн 2021 оны санхүүгийн 2-р улирлын тайлангийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан шинжилгээг хүргэж байна.

Балансын бутцийг авч үзвэл нийт хөрөнгө 26,3 тэрбум төгрөгт хурч урьд оны мөн үетэй харьцуулахад 1,4 дахин өссөний 92,2%-г эргэлтийн хөрөнгө өзэлж байгаа эргэлтийн бус хөрөнгө 7,8% эзэлж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эргэлтийн хөрөнгө 1,7 дахин өссөн байна.

№	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 2-р улирал	2021 оны 2-р улирал	Эерчлэлт	Хувь
1	Эртэлтийн хөрөнгө	9 596 758 800	26 382 846 070	16 786 087 270	1,7 дахин
2	Эргэлтийн бус хөрөнгө	2 307 696 600	2 232 312 480	-75 384 120	-3,27%
	Нийт хөрөнгө	11 904 455 400	28 615 158 552	16 710 703 152	1.4 дахин



Эргэлтийн хөрөнгийг задалж харвал:

- Үүнээс түргэн хөрвөх хөрөнгө нь нийт дүнгээрээ 9,2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 21.2 тэр бум төгрөгт хүрсэн байна. Энэ нь компани 2021 оны сүүлийн хагас жилийн борлуулалт ур ашигаа нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигд хэвийн явуулах нөөц боломж хангалттай байна гэж харж байна.
- Эргэлтийн хөрөнгийн 15,9 % бараа материал эзэлж байгаа нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл онцлогтой холбоотой бөгөөд 2020 оны 2-р улиралтай харьцуулбал 41,1%-р буюу 3,9 тэр бум төгрөг байсаныг 2021 оны 2-р улисагд 15,9 % буюу 4,2 тэр бум төгрөг хүргэсэн нь бараа материалын нөөцийг сайн бурдүүлж чадсан явдал юм. (энэ жил махны үнэ өндөр, мах хөвөр иймд үед нөөц бурдүүлж чадсан нь компаниас явуулж байгаа бодлоготой холбоотой)

ҮЗҮҮЛЭЛИТ



№	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 2-р улирал	2021 оны 2-р улирал	Өөрчлөлт	Хувиар
1	Өр төлбөр	8 855 070 000	24 650 936 262	15 795 866 262	1,78 дахин
2	Эздийн ёмч	3 049 385 400	3 964 222 289	914 836 889	30 %
3	Нийт өр төлбөр	11 904 455 400	28 615 158 552	16 710 703 152	1,4 дахин

МАХИМПЭКС ХК-ИЙН 2021 оны 1-р хагас жилийн тайлан

Эх үүсвэрийн задлаж харвал:




- Нийт өр төлбөрийн дунгээр 24,6 тэр бум төгрөгт хүрч 2020 оны 2-р улиралаас 1.78 дахин буюу 15,7 тэр бум төгрөгөөр өссөний 10 тэрбум төг нь банкны болгино хугацаат зээл байгаа юм. Эздийн өмч урьд оны мөн үеэс 30% буюу 914,8 сая төгрөгөөр өссөн байна.
- Эх үүсвэрийн хувьд өр төлбөр 86,1 %, эздийн өмч 13,9%-р тус тус эзэлж байна.

№	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 2-р улирал	2021 оны 2-р улирал	ЭӨРЧЛӨЛТ	ХУВИАР
1	Нийт орлого	14 508 289 100	31 148 052 474	16 639 763 374	1.4 дахин
2	Нийт зардал	14 801 599 000	30 794 911 449	15 993 312 449	1.08 дахин
3	Цэвэр ашиг	-293 309 900	353 141 025	646 450 925	2,2 дахин

Нийт борлуулалтаар 2021 оны 2-р улиралаар 31.1 тэрбум төг-ийн борлуулалтын орлого хийснээс

- Экстортын борлуулалт 6.0 тэрбум буюу 19,5%
- Нөөцийн махны борлуулалт 11.0 тэрбум буюу 35,3%
- Дотоодын зах зээлийн борлуулалт 14.0 тэрбум буюу 45,2% эзэлж байна.
- Тайлант үед үндсэн үйл ажиллагаандaa голлон анхаарч ажилласны үр дүнд ашигт ажиллагаагаа 2,2 дахин өсгөж чадсан.

НИЙТ БОРЛУУЛАЛТ



Үр Дүн



Компани хэдэн хэдэн компанийт ажлуудыг зохион байгуулсаны дунд нийт зардлаа хамгийн боломжит бага хэмжээнд барьж ажилсан. Уүний тулд:

- Жил бүр зохион байгуулдаг малчдыг дэмжих хөтөлбөрийг ургэлжлүүлэн зохион байгуулнаар махны өргтийг доошшуулж мах бэлтгэлийг хангалттай сайн хийсэн.
- Үйлдвэрлэлийн хэрэгцээний туслах материалыг бөөний үнээр БНХАУ, БНСУ-аас үйлдвэрээс нь татан авах замаар өртгийн зардлыг өсгөхгүй байх мөн цар тахалтай холбоотойгоор бараа бүтээгдэхүн тасалдаах эрсдлийг тооцож дотоодоос өртгийн өсөлтгүй үнээр авах зэрэг ажлуудыг тухай бүр нь шуурхай зохион байгуулж ажиллажээ.
- Тухайн тайлант үеийн ажлын үр дунгээс үзэхэд тус компанийн бизнесийн үйл ажиллагаа 2020 оны эхний хагас жилд цар тахлын улмаас тодорхой хэмжээгээр буурсан ч энэ оны хагас жилд идэвхижжүүлдэг үндсэн үйл ажиллагааны орлого нэмэгдсэнээр ашигт ажиллагааны түвшин өссөн байна.

Компанийн хэтийн төлөв

► Засгийн газрын 2019 оны 329 дугээр тогтоолоор багалсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын заалт, Засгийн газрын мөн оны 23, 26 дугаар тэмдэглэлийн хүнсний хангамж, Унийн тувшиг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд Нийслэлийн хүн амьн хэрэгцээнд 2021-2022 оны өвөл, хаврын улиралд худалдан борлуулах хонь, ямаа, Ухрийн махыг нооцөнд бэлтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

► Шинэ төрлөөр ангилсан Max, дайвар бүтээгдэхүүнийг орчин Үеийн сав баглаа бодиоор шинэчлэн дотоодын зах зээлд нэвтрүүлэх

► Ковид-19 цар тахал намжих үед Орос, Хятад, Иран болон бусад улсуруу хонь, Ухэр, адуны мах болон махан бүтээгдэхүүн экспортоор нийлүүлэлжээр төлөвлөн ажиллаж байна.





Анхаарал хандуулсанд баярлалаа